



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/35

Улаан-Уул

Ажлын хэсэг байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч эрх бүхий иргэн, аж ахуйн нэгжийн газар ашиглах гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах хуулийн хэрэгжилтийг хангуулах, тариалангийн газрыг эргэлтэд оруулах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Баттогтох (Засаг даргын орлогч)

Гишүүд: О.Энхболд (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Т.Мөнхжаргал (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Т.Ариунзаяа (Газрын даамал)

Г.Эрдэнэсан (Татварын улсын байцаагч)

Д.Сайханцэцэг (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Б.Отгонбат (Тариалан эрхлэгчдийн төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Б.Азжаргал (Хөдөө аж ахуй тасгийн мэргэжилтэн)

2. Дээрх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг 2022 оны 04 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201039